



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

### Оноосон нэр өөрчилснийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын зуучлагч “Түвшин оргил” ХХК-ийн оноосон нэрийг “Хэйва инсур” ХХК болгон өөрчилснийг бүртгэсүгэй.

2. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Түвшин оргил” ХХК /Н.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН